

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ОДГЭРЭЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХАНГУУЛАХ							
1.1 Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилго, чиг үүргийн хүрээнд:							
1.	Эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 6 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 1. Энгүүнболор хуяг ХХК 2. Таны говь ХХК 3. Пүшинмон ХХК 4. И Эс Би Би Өү ХХК 5. Энхдэлгэр ХХК 6. Дээдийн говь ХХК	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	2023 оны хяналт шалгалтаар 6 объектод хяналт шалгалт хийсэн.	100%	Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан 13-07/05 дугаартай удирдамжийн дагуу гүйцэтгэлээ. Хяналт шалгалтад хамрагдсан 5 аж ахуй нэгж байгууллагуудыг 07.1.1 кодтой “Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд; 1. Энгүүнболор хуяг ХХК (РД:5596017) нь 34,6%-тай буюу дунд эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 65,3%, илэрсэн зөрчил 16; 2. Пүшимон ХХК (РД:2889625) нь 27,6% буюу бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 72,3%, илэрсэн зөрчил 15; 3. Таны говь ХХК (РД:3616282) нь 83,3% буюу их эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 16%, илэрсэн зөрчил 33;	2024.01.02-2024.12.31	100%

					Таны говь ХХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл, 144.2 дахь заалтад өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна заалтыг, 144.3 Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө заалтыг тус тус зөрчсөн тул зөрчлийн хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд /1500 нэгж/ 1.500.000 төгрөгөөр, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг зөрчсөн бол зөрчлийн тухай хуулийн 10.13.2 дахь /Ажлын байрны төлбөр төлөөгүй хуулийн этгээдийг 10.000 нэгж/ 10.000.000 төгрөгийн торгууль, нөхөн төлбөр 8.140.000 төгрөгөөр буюу нийтдээ 19.640.000 төгрөгөөр торгож зөрчлийн хэргийг Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсэн ба төлбөрийг 100% барагдуулсан байна. 4. И Эс Би Би Өү ХХК (РД:6130836) нь 31,1% буюу дунд эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 68,8%, илэрсэн зөрчил 17; 07.1.2 кодтой Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар шалгахад Таны говь ХХК-ийн нүүрс ачиж буулгах талбайд үйл ажиллагаа явуулдаг 57,1% буюу их эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 42,9%,		
--	--	--	--	--	--	--	--

					илэрсэн зөрчил 26, Энгүүнболор хуяг ХХК нь 24,3%-тай буюу бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 75%, илэрсэн зөрчил 10, Пүшинмон ХХК нь 15,8% буюу бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 84,1%, илэрсэн зөрчил 9, И Эс Би Би Өү ХХК нь 48,3% дунд эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 51,7% тус тус үнэлэгдэж тус бүрт нь гурван хяналтын чиглэлээр улсын ахлах байцаагчийн 108 заалттай 4 албан шаардлага тус тус хүргүүлсэн ба биелэлтийг 3 аж ахуйн нэгж, байгууллага ирүүлсэн байна. 5. Энхдэлгэр ХХК Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудсаар 23% буюу бага эрсдэлтэй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар 53% буюу их эрсдэлтэй үнэлэгдсэн байна.		
2.	Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудад уламжлах	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	2023 онд уул уурхай, зам тээвэр, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй 150 аж ахуйн нэгж, байгууллага урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтаар нийт 1898 зөрчил илрүүлж, 164 аж ахуйн нэгж байгууллагад 1863 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажилласан. Нийт 17 аж ахуйн нэгж байгууллагад 312,7 сая төгрөгийн акт тогтоож, 40 хуулийн этгээдэд		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/07 дугаартай “Уул уурхай, нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 186 аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийгдсэн. Шалгалтын хүрээнд нийт 2920 зөрчил илэрснээс 218 буюу 7.4 хувийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын (ахлах) байцаагчийн 1793 заалттай 161 албан шаардлага хүргүүлж, 47 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 76,250.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулсан байна. Нийт 370 хүний илүү цаг, ээлжийн амралт, шөнийн цагийн нэмэгдэл хөлс, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зэргийг нөхөн	2024.01.02-2024.12.31	100%

			51,2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.		олгуулахаар 44 аж ахуйн нэгж байгууллагад 573,435,800 (таван зуун далан гурван сая дөрвөн зуун гучин таван мянга найман зуу) төгрөгийн улсын ахлах байцаагчийн актыг тогтоосон байна. Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн салбарт илэрсэн нийтлэг зөрчлийг арилгах, үйлдвэрлэлийн ослын тоог бууруулах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, тухайн салбарт ажил хөдөлмөр эрхэлж буй хүний хөдөлмөрлөх эрхийг хангахад чиглэсэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Зам, тээврийн хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн байна.		
3.	Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах тухай Салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгаврыг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэх	Яамдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, агентлаг, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хороо, зөвлөл, Монголын үйлдвэрчний эвлэлийн хороо, Ажил олгогч эздийн холбоо, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн	Сүүлийн 5 жилд зам, тээврийн салбарт нийт 174 үйлдвэрлэлийн осол бүртгэгдэж, 60 хүн хөнгөн, 95 хүн хүнд гэмтэж, үйлдвэрлэлийн ослын улмаас 19 хүн нас барсан тохиолдол бүртгэгдсэн байна.		1. Салбарын улсын ерөнхий байцаагчийн гаргасан 5 албан даалгаврыг яамдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, агентлаг, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хороо, зөвлөл, Монголын үйлдвэрчний эвлэлийн хороо, Ажил олгогч эздийн холбоо, Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг 30 гаруй байгууллагад албан бичгийн хамт хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. 2. Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах тухай Салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгаврыг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлсэн.	2024.01.02-2024.12.31	100%

		танхимд хүргэгдэнэ.					
4.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ Зөрчил арилгалт /хувь/	2023 онд 33 иргэн, 20 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна.	-	1. 2024 онд аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 32 албан бичиг, 14 өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэн ажилласан байна. 2. Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Ш.Хонгорзултай хамтран Дарханфлюорит ХХК-д гүйцэтгэлийн, Монгол шуудан ХК-иудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд 18 заалттай албан шаардлага хүргүүлсэн байна.	2024.01.02- 2024.12.31	100%
2. ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ							
2.1 Эрсдэлд суурилсан салбарын хяналтыг хэрэгжүүлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэн мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар иргэдийн нийгмийн баталгааг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн систем бүхий үр дүнтэй цогц хяналтыг хэрэгжүүлэх стратегийн зорилтын хүрээнд:							
5.	Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах	Төлөвлөгөөт 1 хяналт шалгалтын танилцуулга нэгтгэсэн байна.	2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Зам тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 07/14 дүгээр удирдамжийн дагуу зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 161 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдахаар төлөвлөгдсөнөөс 13 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа зогссон, 2 улсын байцаагчгүй, 1 хаяг байршил тодорхойгүй, нийт 145	50%	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/07 дугаар тушаалын хавсралтаар баталсан 2024 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг тус тус үндэслэн Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Зам тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 13-07/05 дугаартай удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5 дугаар баг, Цагаан хад суурьшлын бүсэд нүүрс ачиж, буулгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 13 аж ахуй нэгж, байгууллага буюу 52%-д нь хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр	2024.01.02- 2024.12.31	100%

			аж ахуйн нэгж, байгууллага буюу 90,1% нь хамрагдсан байна. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагаас “Их” эрсдэлтэй 75 буюу 51,7%, “Дунд” эрсдэлтэй 83 буюу 57,2%, “Бага” эрсдэлтэй 71 буюу 48,9% тус тус үнэлэгдсэн байна. Мөн хяналт шалгалтад 200 гаруй тоног төхөөрөмжтэй 145 аж ахуйн нэгж, байгууллагын 9452 ажилтан хамрагдаж, 4494 зөрчил илрүүлэхэд хууль сахин мөрдөлт 64,7% байсан ба нийт 248.823.097 (Хоёр зуун дөчин найман сая найман зуун хорин гурван мянга ерэн долоо) төгрөгийн акт, торгууль, 121 албан шаардлага, 6 удаагийн хамтарсан сургалт, сурталчилгаа хийж ажилласан байна.		давхардсан тоогоор нийт 39 удаагийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 13 аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 989 зөрчил илрүүлж, 457 заалттай улсын ахлах байцаагчийн 13 албан шаардлага, хяналтын 3 чиглэлээр 53,500,000 төгрөгийн торгууль ногдуулсан нь 100% биелэлттэй, 11 аж ахуй нэгж, байгууллагад 203,008,312.6 төгрөгийн акт тавьсан ба 76,3% биелэлттэй байна.		
6.	Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр төлөвлөгөөт хяналт	Төлөвлөгөөт 1 хяналт шалгалтын танилцуулгад дүн шинжилгээ хийж, холбогдох	2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Зам тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр	100%	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 56 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдахаар төлөвлөгдсөнөөс 49 аж ахуйн нэгж, байгууллага буюу 87.5% нь хамрагдаж, 7 буюу 12.5 хувь нь шалгалтад хамрагдаагүй үйл ажиллагаа явуулаагүй зогссон, 56 аж ахуйн	2024.01.02-2024.12.31	100%

	шалгалтад шинжилгээ холбогдох байгууллагуудад уламжлах	дүн хийж	газарт уламжлана.	төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 07/14 дүгээр удирдамжийн дагуу зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 161 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдахаар төлөвлөгдсөнөөс 13 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа зогссон, 2 улсын байцаагчгүй, 1 хаяг байршил тодорхойгүй, нийт 145 аж ахуйн нэгж, байгууллага буюу 90,1% хамрагдсан байна. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагаас “Их” эрсдэлтэй 75 буюу 51,7%, “Дунд” эрсдэлтэй 83 буюу 57,2%, “Бага” эрсдэлтэй 71 буюу 48,9% тус тус үнэлэгдсэн байна. Мөн хяналт шалгалтад 200 гаруй тоног төхөөрөмжтэй 145 аж ахуйн нэгж, байгууллагын 9452 ажилтан хамрагдаж, 4494 зөрчил илрүүлэхэд хууль сахин мөрдөлт 64,7% байсан ба нийт 248.823.097 (Хоёр зуун дөчин найман сая найман зуун хорин гурван мянга ерэн	нэгж байгууллагын 53.8% буюу 30 нь тээвэр, агуулахын, 44.6% буюу 25 нь авто зам, засвар, арчлалтын, 1.6% буюу 1 аж ахуйн нэгж нь хот тохижилтын үйл ажиллагаа явуулж байна. Шалгалтад хамрагдсан 49 аж ахуйн нэгж, байгууллагад 3896 ажилтан хөдөлмөр эрхэлж байгаагаас 1395 буюу 35.8% нь эмэгтэйчүүд, 70 буюу 1.8%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтаар нийт 1436 зөрчил илрүүлж, 73 аж ахуйн нэгж байгууллагад 773 заалттай албан шаардлага хүргүүлсэн ба 139.692.7 (нэг зуун гучин есөн сая зургаан зуун ерэн хоёр мянга долоон зуу) төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 37,100.0 (гучин долоон сая нэг зуу) төгрөгийн торгууль тус тус ногдуулж, 92,9% барагдуулсан байна. Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтад дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудад уламжлахаар төлөвлөж байна.		
--	--	-------------	----------------------	--	--	--	--

			долоо) төгрөгийн акт, торгууль, 121 албан шаардлага, 6 удаагийн хамтарсан сургалт, сурталчилгаа хийж ажилласан байна.				
3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
7.	Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулахад санал өгөх	Журам-2	Салбарын хяналт шалгалтад шаардлагатай журам, заавруудад санал өгч ажилласан.	100%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын журам боловсруулахад санал өгсөн.	2024.01.02-2024.12.31	100%
8.	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, хуулийн этгээдүүдийг хууль зүйн мэдээллээр хангасан байна.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэсэн байна.	2023 онд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гүйцэтгээгүй байна.	50%	Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5 дугаар баг, Цагаан хад суурьшлын бүсэд нүүрс ачиж буулгах талбайд үйл ажиллагаа явуулж буй “Таны говь” ХХК-нд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал зохих орон тоонд ажиллуулаагүй шалтгаанаар Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасны дагуу 1500 нэгж буюу 1,500,000 төгрөгөөр торгосон ба төлбөрийг 100% барагдуулсан байна.	2024.01.02-2024.12.31	100%
4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
9.	Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад орны болон олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтыг	2024 онд төслийн хүрээнд 2 сургалт зохион байгуулсан байна.	2023 онд “Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих техникийн туслалцааны төсөл”-ийн хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын	50%	Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь” сэдэвт улсын байцаагчдын нэгдсэн сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрүүдэд Удирдлагын академитай хамтран зохион байгуулж, яам, агентлаг, аймаг, нийслэл,	2024.01.02-2024.12.31	100%

	танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулах		улсын байцаагчдыг болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжүүдийн удирдах албан тушаалтнуудыг чадавхжуулах 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 190 хүн хамрагдсан.		дүүргийн 115 улсын (ахлах) байцаагчдыг хамруулав. “Сургалтын модуль хөтөлбөрийн практик сургалт”-ыг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Удирдлагын академитай хамтран зохион байгуулж, мэргэшсэн 30 улсын (ахлах) байцаагчийг хамруулав. Бриж-2 төслийн хүрээнд хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдад зориулсан “Албадан хөдөлмөр” сэдэвт сургалтад 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрүүдэд 30 улсын (ахлах) байцаагчийг хамруулав.		
10.	Бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зориулсан сургалтыг зохион байгуулахад оролцох	- Зохион байгуулсан сургалтын тоо - Хамрагдсан хүний тоо	2023 онд ХАБЭА-н Үндэсний чуулганд зохион байгуулалтын ажлын хэсэгт оролцсон.	100%	Зам, тээврийн үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран зам, тээврийн салбар үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад гардаг нийтлэг зөрчил, болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан ба хяналт шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагуудын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	2024.01.02-2024.12.31	100%
11.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн явц, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /хувь/-90-аас доошгүй	2023 онын эхний хагас жил 90%, сүүлийн хагас жилд 90%-ын үнэлгээтэйгээр тус тус ажлаа дүгнүүлсэн.	100%	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, сарын тайланг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.	2024.01.02-2024.12.31	100%
12.	Удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгавраар ажиллах	Үүрэг даалгаврын тоо	Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж ажилласан.	100%	1. Газрын 1,2 дугаар улиралд хийсэн хурлын тэмдэглэл хөтөлсөн. 2. Газрын зохион байгуулалтын баримт бичгүүдийн эмх, цэгц, дугаар олгох ажлыг хариуцан ажилласан. 3. 2024 онд Салбарын хяналтын газрын чиг үүргийг хэрэгжүүлж буй орон нутаг, нийслэл,	2024.01.02-2024.12.31	100%

					дүүрэгт шинээр эрх авсан хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын 28 улсын (ахлах) байцаагчдын үнэмлэх, тэмдэг олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн судалгаанд оруулж ажилласан байна. 4. Улсын (ахлах) байцаагчийн 16 эрх олгох, 15 эрх цуцлах сайдын тушаалын төслийг боловсруулж, баталгаажуулж ажилласан байна.		
13.	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилтэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон орон нутгийн салбар нэгжүүдтэй хамтран үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах	Аймаг, нийслэл, дүүргийн 15 төв хамрагдана.	Өмнө нь асрамж, халамж, сэргээн засах чиглэлээр үзлэг шалгалт хийгдээгүй байна.	100%	Асрамж, халамж, сэргээн засах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын мөрдөж буй стандартын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/133 дугаар тушаалаар удирдамж, үзлэг шалгалтад хамрагдах 15 асрамж, халамжийн төвийн нэр, үзлэг шалгалт хийх асуумж, судалгааны хамт аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлж, үзлэг шалгалтын үйл ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 07-22-ны өдрүүдэд зохион байгуулж, танилцуулгыг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн байна. Удирдамжийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд үзлэг шалгалтыг хийсэн ба нийт 14677 хүүхдэд хөдөлгөөн, хөдөлмөр, хэл заслын үйлчилгээ үзүүлсэн байна.	2024.01.02 2024.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
14.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах тухай				Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын		

	албан даалгавар боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэх	1 албан даалгавар, 1 албан бичиг	2023 онд Улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001 албан даалгаварыг хүргүүлсэн байна.	100%	хэрэгжилтийг хангаж, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001-04 дугаартай албан даалгаврыг Зам, тээврийн хөгжлийн яамны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд болон 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Монголын Үйлдвэрчний эвлэлийн хороо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 02/873 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.	2023.01.02-2023.12.31	100%
15.	Газраас 2023 онд гаргасан баримт бичгийг архивлах	13 баримт бичиг	2022 оны баримт бичгүүд Архивын ерөнхий газарт хадгалагдсан. Яаманд архивын нэгж үүсээгүй байна.	100%	Салбарын хяналтын газрын 2023 онд гаргасан зохион байгуулалтын 13 төрлийн баримт бичгийг стандартын дагуу цэгцэлж, товьёглож, үдэж архивын ажилтанд хүлээлгэж өгөхөд бэлэн болгосон. Мөн улсын ахлах байцаагчийн албан шаардлага, акт, дүгнэлт, зөвлөмж, салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар, шийдвэр зэргээр цахим архив үүсгэж ажилласан.	2023.01.02-2023.12.31	100%
16.	Хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг батлуулах	2 төрөл	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/50 дугаар тушаалаар хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх 162 байцаагчдад улсын (ахлах) байцаагчийн эрх олгосон.	100%	Салбарын хяналтын газрын чиг үүргийг хэрэгжүүлэх 77 улсын (ахлах) байцаагчийн 2 албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ, харьцуулалт хийж, танилцуулга /Ppt/, төрийн албаны зөвлөлийн тогтоолын төслийг бэлтгэж салбар зөвлөл болон Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн ба хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдын албан	2024.01.02-2024.12.31	100%

					тушаалын тодорхойлолт 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан байна.		
17.	Хэвлэмэл хуудасны хадгалалт, зарцуулалтыг хариуцаж, хяналт тавих, хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, тэмдгийн дардасны судалгаа гаргах	162 улсын (ахлах) байцаагч	Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад очсонтой холбогдуулан улсын (ахлах) байцаагч нарт улсын (ахлах) байцаагчийн эрх олгосон.	100%	1. Засгийн газрын 06 дугаар тогтоолын “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-ын 1.12-т төрийн захиргааны төв байгууллага нь хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дардасны судалгааг авч, хяналт тавих заалтын дагуу салбарын хяналтын газрын чиг үүргийг хэрэгжүүлж буй яам, агентлаг, орон нутаг, нийслэл, дүүргийн 162 улсын (ахлах) байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дардасны судалгаа гаргаж ажилласан. 2. Яамны нэр, зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор яам, харьяа агентлаг, аймаг, дүүрэгт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, нэгжийн удирдлага, улсын (ахлах) байцаагчдын 221ш тэмдгийн дардасны резин, үнэмлэхний хавтасны нэрийг солиулж холбогдох агентлагуудад хүлээлгэн өгч, бүртгэлжүүлж ажилласан байна.	2024.01.02-2024.12.31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
18.	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт, дадлага эзэмшүүлэх нэгдсэн сургалт, семинарт хамрагдах	2 сургалт	2023 онд гадаадын 1, үндэсний 4 чадавхжуулах сургалтад хамрагдсан.	100%	1. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд “Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь” сэдэвт	2024.01.02-2024.12.31	

					улсын байцаагчдын нэгдсэн сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд 2. “Сургалтын модуль хөтөлбөрийн практик сургалт”-ыг 2024 оны 11 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд тус тус хамрагдсан байна. 3. Бриж-2 төслийн хүрээнд хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдад зориулсан “Албадан хөдөлмөр” сэдэвт сургалтад 2024 оны 10 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд хамрагдсан.		100%
19.	Монгол бичиг бие даан сурах	Бие дааж сурах	Монгол бичгийн дунд шатны мэдлэгтэй.	100%	Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах хөтөлбөрийн хүрээнд бие даан уншиж, бичих чадвараа сайжруулсан байна.	2024.01.02-2024.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ,
ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

...../Г.ОДГЭРЭЛ/
(Нэр, гарын үсэг)

2024.12.09
(Огноо)